



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/103

Бат-Өлзий сум

Өрхийн мэдээллийн сангийн судалгаа зохион  
байгуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн “Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгааг зохион байгуулах тухай” А/88 дугаар тушаал, Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/16-А/04 дүгээр хамтарсан тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох хосолсон аргачлал”-аар нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн мэдээллийг шинэчлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Орхонтуул (Засаг даргын орлогч)  
Нарийн бичгийн дарга: Н.Долгормаа (Нийгмийн халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд: Б.Орбиш (Хөдөлмөр эрхлэлт хариуцсан мэргэжилтэн)  
Ж.Нямтогтох (1 дүгээр багийн Засаг дарга)  
Д.Бямбасүрэн (2 дугаар багийн Засаг дарга)  
С.Төмөр (3 дугаар багийн Засаг дарга)  
Г.Пүрэвтогтох (4 дүгээр багийн Засаг дарга)  
Г.Бямбагарав (5 дугаар багийн Засаг дарга)  
Д.Дэмиддагва (6 дугаар багийн Засаг дарга)

2. Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгааны ажлыг дээд шатны байгууллагаас ирүүлсэн удирдамж, чиглэл, аргачлалын дагуу үр дүнтэй зохион байгуулж, тайланг заасан хугацаанд хүргүүлэн ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Н.Орхонтуул)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

My Doc Zakhiramj /ZD/ 2023

622301246